

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Аудитор: У.Ербол  
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>6</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>16</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>20</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>20</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>20</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>20</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	<b>20</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>20</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>21</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар.....</b>	<b>21</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>21</b>
<b>5.1 Төлбөрийн акт .....</b>	<b>22</b>
<b>5.2 Албан шаардлага .....</b>	<b>22</b>
<b>5.3 Зөвлөмж .....</b>	<b>22</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>23</b>

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	<b>БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА Ш.МАРАТ ТАНАА</b>
2023.08.24 № 230	
танай _____	-ны № _____ -Т
<b>Өөрчлөлтгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p><b>Асуудлыг онцолсон хэсэг</b></p> <p>2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p> <p><b>Аудитын гол асуудал</b></p> <p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p> <p><b>Бусад асуудлын хэсэг</b></p> <p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p> <p><b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b></p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,154,282.14</b>	<b>78,438,280.14</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	33,768,998.00
34600	Урьдчилж гарсан зардал		33,768,998.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,154,282.14	44,669,282.14
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,678,520.50	3,678,520.50
35110	Тусгай зориулалттай материал	3,678,520.50	3,678,520.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	39,875,761.64	40,390,761.64
35410	Бичиг хэргийн материал	704,107.00	659,107.00
35420	Аж ахуйн материал	32,383,905.64	32,443,905.64
35440	Түлш, шатах тослох материал		500,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,787,749.00	6,787,749.00
35600	Мал амьтад	600,000.00	600,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>208,256,742.30</b>	<b>351,234,021.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	208,256,742.30	351,234,021.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	206,024,742.30	349,002,021.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	169,764,856.00	176,034,856.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,832,474.08)	(14,750,928.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,435,053.00	216,242,740.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,916,054.44)	(57,983,421.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,625,427.80	55,625,427.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,972,444.55)	(54,146,893.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,079,595.00	22,079,595.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,663,970.00)	(16,569,594.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,703,973.00	42,703,973.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,199,219.43)	(20,233,733.03)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,232,000.00	2,232,000.00
39301	Програм хангамж	1,995,000.00	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,995,000.00)	(1,995,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,232,000.00	2,232,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>252,411,024.44</b>	<b>429,672,301.49</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>530,465.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	530,465.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	530,465.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	530,465.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	530,465.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>252,411,024.44</b>	<b>429,141,836.49</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	252,411,024.44	429,141,836.49

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,786,368.32	212,786,368.32
51101	Өмч: - төрийн	212,786,368.32	212,786,368.32
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(23,031,621.92)	153,699,190.13
51210	Өмнөх үеийн үр дүн	(26,384,507.00)	(23,031,621.92)
51220	Тайлант үеийн үр дүн	3,352,885.08	176,730,812.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,656,278.04	62,656,278.04
51600	Нөөцийн сан		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>252,411,024.44</b>	<b>429,672,301.49</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>555,788,018.00</b>	<b>844,623,687.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,383,218.00</b>	<b>3,450,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,383,218.00	3,450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,383,218.00	3,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,383,218.00	3,450,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>551,404,800.00</b>	<b>841,173,687.95</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	147,307,687.95
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	147,307,687.95
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,855,000.00	6,816,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		270,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	4,046,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,855,000.00	2,500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	542,549,800.00	687,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	542,549,800.00	687,050,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>552,435,132.92</b>	<b>667,892,875.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>552,435,132.92</b>	<b>667,892,875.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	550,281,508.92	631,157,104.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	406,909,000.00	407,075,000.00
210101	Үндсэн цалин	326,054,507.00	294,943,043.00

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	66,119,293.00	67,407,557.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,735,200.00	14,735,200.00
210105	Гэрээт ажлын хөлс		29,989,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,692,800.00	46,770,702.00
210201	Тэтгэврийн даатгал	35,416,400.00	31,798,002.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,069,100.00	3,743,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,255,300.00	2,994,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	813,800.00	748,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,138,200.00	7,486,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,877,908.00	14,147,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,453,970.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	10,888,712.00	12,095,100.00
210303	Цэвэр, бохир ус	535,226.00	457,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,269,645.00	6,139,747.00
210401	Бичиг хэрэг	298,030.00	336,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,116,245.00	2,797,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,870.00	920,887.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,500.00	2,085,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	370,000.00	276,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	370,000.00	276,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,360,500.00	197,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,500.00	-
210604	Урсгал засвар	1,310,000.00	197,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,935,602.00	2,652,626.00
210702	Дотоод албан томилолт	1,935,602.00	2,652,626.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	59,641,824.00	120,509,621.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,317,624.00	120,245,501.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	165,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,700.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	49,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,700.00	14,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,224,229.92	33,388,808.90

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,719.00	538,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,782,510.92	23,100,408.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,153,624.00</b>	<b>36,735,771.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		- 23,490,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		- 23,490,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,153,624.00</b>	<b>13,245,371.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,153,624.00	13,245,371.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,352,885.08</b>	<b>176,730,812.05</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,352,885.08</b>	<b>176,730,812.05</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>555,788,018.00</b>	<b>697,316,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,383,218.00</b>	<b>3,450,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,383,218.00	3,450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,383,218.00	3,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,383,218.00	3,450,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>551,404,800.00</b>	<b>693,866,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,855,000.00	6,816,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		270,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	4,046,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,855,000.00	2,500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	542,549,800.00	687,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	542,549,800.00	687,050,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>545,788,018.00</b>	<b>678,546,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,788,018.00</b>	<b>678,546,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>543,634,394.00</b>	<b>641,810,229.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	406,909,000.00	407,075,000.00

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	326,054,507.00	294,943,043.00
210102	Нэмэгдэл	66,119,293.00	67,407,557.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,735,200.00	14,735,200.00
210105	Гэрээт ажлын хөлс		29,989,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,692,800.00</b>	<b>46,789,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,416,400.00	31,817,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,069,100.00	3,743,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,255,300.00	2,994,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	813,800.00	748,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,138,200.00	7,486,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,521,726.00</b>	<b>13,643,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,715,326.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	11,271,174.00	11,591,100.00
210303	Цэвэр, бохир ус	535,226.00	457,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,383,742.00</b>	<b>6,626,982.00</b>
210401	Бичиг хэрэг	412,127.00	291,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,116,245.00	3,294,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,870.00	896,622.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,500.00	2,145,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>440,000.00</b>	<b>276,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	276,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,360,500.00</b>	<b>197,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,500.00	-
210604	Урсгал засвар	1,310,000.00	197,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,263,602.00</b>	<b>2,652,626.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,263,602.00	2,652,626.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>62,526,824.00</b>	<b>154,263,121.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,202,624.00	153,999,001.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	165,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,700.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	49,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,700.00	14,700.00

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	536,200.00	10,286,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	536,200.00	536,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,153,624.00</b>	<b>36,735,771.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		- 23,490,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		23,490,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,153,624.00	13,147,997.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,153,624.00	13,147,997.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		- 97,374.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		97,374.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>10,000,000.00</u></b>	<b><u>18,770,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,000,000.00</b>	<b>18,770,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,000,000.00</b>	<b>18,770,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	10,000,000.00	18,770,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,000,000.00	18,770,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(10,000,000.00)</u></b>	<b><u>(18,770,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		- -
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		- -
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		- -

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92		252,411,024.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92	0.00	252,411,024.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92	0.00	252,411,024.44
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92	0.00	252,411,024.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	-23,031,621.92	0.00	252,411,024.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			176,730,812.05		176,730,812.05
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,786,368.32	62,656,278.04	153,699,190.13	0.00	429,141,836.49

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	745,183,100.00	677,352,003.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	745,183,100.00	677,352,003.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	721,692,700.00	653,861,603.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	407,075,000.00	407,075,000.00
210101	Үндсэн цалин	303,843,800.00	294,943,043.00
210102	Нэмэгдэл	58,506,800.00	67,407,557.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,735,200.00	14,735,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,989,200.00	29,989,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,839,700.00	46,789,700.00
210201	Тэтгэврийн даатгал	31,867,000.00	31,817,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,743,200.00	3,743,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,994,500.00	2,994,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	748,600.00	748,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,486,400.00	7,486,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,643,300.00	13,643,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,594,900.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	11,591,100.00	11,591,100.00
210303	Цэвэр, бохир ус	457,300.00	457,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,857,000.00	3,856,982.00
210401	Бичиг хэрэг	291,000.00	291,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,524,000.00	2,524,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	897,000.00	896,622.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,000.00	145,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	276,000.00	276,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	276,000.00	276,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	197,300.00	197,300.00
210604	Урсгал засвар	197,300.00	197,300.00

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	954,000.00	954,000.00
210702	Дотоод албан томилолт	954,000.00	954,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	239,314,200.00	171,533,121.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239,000,000.00	171,269,001.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	31,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,500.00	49,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,700.00	14,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,536,200.00	9,536,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	9,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	536,200.00	536,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,490,400.00	23,490,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,490,400.00	23,490,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,490,400.00	23,490,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	745,183,100.00	677,352,003.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	741,683,100.00	673,902,003.00
132001	Орон нутгийн төсвөөс	741,683,100.00	673,902,003.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	3,500,000.00	3,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	3,450,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	44	44
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	33	36
620003	Үйлчлэх ажилтан	10	7
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>44</b>	<b>44</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34	31
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	13

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,718,626.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,718,626.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,718,626.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,770,000.00
210402	Тээвэр, шатахуун	770,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,698,626.00
210702	Дотоод албан томилолт	1,698,626.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,250,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	6,816,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,816,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	270,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,046,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зорилгыг байгаль орчин, аялал жуулчлалын багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлал ногоон хөгжлийг дэлгэрүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд: “Аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах”

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, , Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчны шинэчлэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг зохион байгуулахад оршино.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Байгаль орчны хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газрын даргын 2020 оны А/13 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 177.3 сая төгрөгөөр буюу 70.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Урьдчилж гарсан зардал		33,768,9	33,768,9
Бараа материал	44,154,3	44,669,3	515,0
Үндсэн хөрөнгө	208,256,7	351,234,0	106,977.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>252,411,0</b>	<b>429,672,3</b>	<b>177,261.3</b>
Өр төлбөр		530,4	530,4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	252,411,0	429,141,8	176,730.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>252,411,0</b>	<b>429,672,3</b>	<b>177,261.3</b>

Жилийн эцэст 33.7 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй гарсан байна. Үүний 28.7 сая төгрөг нь "ПГЖМ" ХХК-аас нийлүүлэх тракторын үнийн 50 хувь, 5 сая төгрөг нь "Ранго-трэйбл" ХХК-ийн отоглох хоноглох цэг барих урьдчилгаа юм.

Бараа материалын данс 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 106,9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгө 17.2 сая төгрөг, БОАЖЯ-наас нийлүүлсэн 147.3 сая төгрөгийн 2 авто машинаар хөрөнгө нэмэгдэж, элэгдлийн зардлын 23.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөрийн данс 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түлш халаалтын өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 176.7 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 742.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас түлш халаалтын зардлыг 1.7 сая төгрөгөөр нэмж, бусад зардлуудыг хэвээрээ баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант онд төсвийн тодотгол хийгдэж улсын төсвөөс санхүүжих зардлыг 745.2 сая төгрөгөөр баталж анх баталсан төсвөөс 2.9 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 741.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 673.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3.45 сая төгрөгийн орлого бүрдүүлж, санхүүжилтээс 67.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, жилийн эцэст 13.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 677.0 сая төгрөг буюу 90.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байгаль орчныг хамгаалах, нөхөх сэргээх зардал	239,000.0	171,269.0	67,731.0	71.6%
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	482,692.7	482,642.6	50.1	99.9%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	23,490.4	23,490.4	0	100%
	<b>Дүн</b>	<b>745,183.1</b>	<b>677,402.0</b>	<b>67,781.1</b>	<b>90.9%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Хоггүй- Өлгий” аян зохион байгуулахад 1.2 сая төгрөг, аймгийн ИТХ-ын тогтоолоор байгаль орчны гэмт хэргээс сэргийлэх сургалт зохион байгуулахад 2.8 сая төгрөг, БОАЖЯ-ны уур амьсгалын сангаас биотехникийн арга хэмжээнд 2.5 сая төгрөг, аймгийн Зоонозын өвчин, судлалын төвөөс тээвэр шатахууны зардалд 0.3 сая төгрөг тус тус олгож, байгууллагын тээвэр шатахуун, дотоод томиллолт, БҮТЭЗ болон бараа үйлчилгээний бусад зардлуудад зарцуулж, 0.09 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 17 төсөл хөтөлбөрт 171.3 сая төгрөг зарцуулж, 137.6 сая төгрөгийн 11 төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжиж, 33.7 сая төгрөгийн 6 төсөл, хөтөлбөр дараа онд шилжсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 50 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 552.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нь улсын төсвийн санхүүжилтийн хэмнэсэн 13.1 сая төгрөгийг жилийн эцэст төсөвт төвлөрүүлсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2022 онд нийт 898.0 сая төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар гэрээний хэрэгжилттэй холбоотой 4.8 сая төгрөгийн, бүрдэл дутуу баримттай холбоотой 3.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

мянган төгрөг

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	8,498,0	1	8,498,0	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>8,498,0</b>	<b>2</b>	<b>8,498,0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 0.6 сая төгрөгийн 2 алдааг залруулав. Үүнд:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогын дансанд тусгасан 0.3 сая төгрөгийг залруулж төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж дансанд тусгав.

Аудитаар нийт 11.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1.3 сая төгрөгийн нэг зөрчилд зөвлөмж өгсөн болно.

### **5.1 Төлбөрийн акт**

Байхгүй.

### **5.2 Албан шаардлага**

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. “Грийн-Элдорадо” ХХК-д гоёл чимэглэл, жимсний модны 9 төрлийн 1107 ширхэг суулгац худалдан авахад 9.9 сая төгрөгийг гэрээний дагуу шилжүүлж, 1107 ширхэг суулгац хүлээн авсан боловч хүлээж авсныг нотлох орлогын баримт, нийлүүлсэн компанийн зарлагын баримтгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

##### 2.1. Илрүүлэлт:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хүрээнд тус байгууллагаас нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах чиглэлээр “Эрдэнийн судар” ХХК-д 1.3 сая төгрөг шилжүүлж 1000 ширхэг тараах материал / брошюр/-ыг хэвлүүлж олон нийтэд тараасан боловч орлого авч данс бүртгэлд тусгаагүй, тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

##### 2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг , мөрдөж ажиллах, гарсан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд алдаатай тусгасан 0.3 сая төгрөгийн залруулав	2	540.0			2	540.0	2	540.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>540.0</b>			<b>2</b>	<b>540.0</b>	<b>2</b>	<b>540.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого авч данс бүртгэлд тусгаагүй	1	9,900.0			1	9,900.0						
тооцооны данс дамжуулахгүйгээр бүртгэж тайлагнасан	1	1,300.0					1	1,300.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>10,200.0</b>			<b>1</b>	<b>9,900.0</b>	<b>1</b>	<b>1300.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								